



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

"Мэргэжлийн боловсрол, сургалт түншлэл" төрийн бус байгууллага/VETP/, "Эм Си Ди Эс" ХХК зөвлөн туслах үйлчилгээний байгууллага/MCDS/-аас Үйлдвэрлэл урлалын политехник коллежтой хамтран МБСБ-ын удирдлагуудад зориулсан семинарийг өнөөдөр тус сургуулийн соёлын танхимд зохион байгууллаа

Тус үйл ажиллагаанд Сингапур улсын эксперт багш, олон улсын зөвлөх "Томас Ёо оролцож, "Тогтвортой байдал ба ажил мэргэжлийн ирээдүй – аж ахуйн нэгж, сургууль багш нарт тулгамдах сорилтууд ба боломжууд" сэдэвт сургалт явууллаа



Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь hicheel.pas.mn сургалт удирдлагын системийг хөгжүүлэн сургалтын үйл ажиллагаандаа ашигладаг билээ Энэхүү сургалт удирдлагын системийг хөгжүүлэн суралцагчдын нэмэлхийг цахим хэлбэрт шилжүүллээ Мөн суралцагчдыг сургуулийн дотоод дүрэм журмыг сахин мөрдүүлэх зорилгоор оноожуулан цахим хэлбэрээр үнэлэх боломжийг бүрдүүллээ

ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мэргэжлийн Боловсрол Сургалтын Байгууллагын Улаанбаатар бүсийн оюутан суралцагчдын аварга шалгаруулах Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн нэрэмжит волейболын тэмцээн амжилттай зохион байгуулагдаж байна.

Тэмцээнийг ҮҮПК-ийн захирал Д.Буяндэлгэр нээж, "Сэтгэл шингэсэн говь" морин хуурын аялгуугаар өгөгдлийн сангийн оператор 16 ангийн суралцагч Э.Болд, "Эрэмгий" дуугаар Сийлбэрчин 1а ангийн суралцагч Э.Лувсан, "Амар байна уу" бүжгийг ҮҮПК-ийн Их Монгол бүжгийн хамтлаг нийт зочин баг тамирчдадаа мэндчилгээ дэвшүүллээ Мөн тэмцээний үеэр болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар СБД Цагдаагийн 10-р хэлтсийн эргүүлийн ахлах дэслэгч н.Ууганбаяр нийт баг тамирчдад товч мэдээлэл хүргэлээ. Тэмцээнд нийт 11 сургуулийн 30 баг тамирчид оролцсон байна.





НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА.

БНСУ-ын Кён-Ин эмэгтэйчүүдийн их сургуультай хамтын ажиллагаагаа өргөжүүлж 1+1 хөтөлбөрийг "Гоо засалч" мэргэжлээр зохион байгуулах санамж бичигт гарын үсэг зурлаа. ҮҮПК нь Монгол улсын мэргэжилтэй ажилтан бэлтгэх төрийн бодлогын хэрэгжилтийг хангаж 34 төрлийн мэргэжлээр Мэргэжлийн болон Техникийн боловсрол олгож байгаа билээ. Тус сургууль нь Олон улсын өндөр хөгжилтэй орнуудын сургалтын хөтөлбөрт нийцсэн сургалтыг явуулах зорилтыг дэвшүүлэн БНСУ-ын Кён-Ин эмэгтэйчүүдийн их сургуультай хамтарсан хөтөлбөрийг Гоо засалч мэргэжлээр хамтран хэрэгжүүлэх санамж бичгийг байгууллаа.



НОМЫН НЭЭЛТ БОЛОО

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Үсчний мэргэжлийн багш Монгол Улсын мастер үсчин, зөвлөх багш Д.Одгэрэл нь мэргэжлийн багийнхантайгаа хамтран "ҮСЧИН МЭРГЭЖЛИЙН ОНОЛ, ТЕХНИК" гурван боть номыг зохиож нээлтээ хийлээ.

БНСУ-ЫН КЁН-ИННИЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын политехник коллеж нь Агаарын хөлгийн үйлчилгээний ажилтан мэргэжлийн ажилтанг БНСУ-ын Кён-Иний эмэгтэйчүүдийн их сургуультай хамтран бэлтгэж 5 ээлжийн төгсөгчдийг БНСУ-д сургаж байгаа билээ.

Мөн 2023-2024 оны хичээлийн жилд Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний ажилтан мэргэжлээр элсэлт авч сургалт явуулж байна.

Аялал жуулчлал өндөр хөгжсөн тус улсын хэл, соёл, мэргэжилд суралцан сургуулийнхаа нэр хүндийг өндөрт өргөж яваа төгсөгч суралцагч нарын уулзалтыг сургуулийн удирдлага, төлөөлөгч нар БНСУ-ын Кён-Ин их сургууль дээр зохион байгууллаа.



САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА.

Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж болон МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөл хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.



☎ 976+11350209

f Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж

🌐 www.pas.mn



НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ

1+1 ХӨТӨЛБӨР

ҮҮПК нь БНСУ-ын Сожон их сургуультай Гагнуурчин мэргэжлээр 1+1 хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа билээ

Тус хөтөлбөрийн хүрээнд Сожон их сургуулийн үйл ажиллагаатай танилцан цаашид хөтөлбөрийн тоог нэмэгдүүлж, мэргэжлүүдийн хөтөлбөр боловсруулалтыг хамтран хийх БНСУ-ын ЗГ-н ODA төслийг боловсруулан шалгаруулалтад орох ажлыг эхлүүлэх зэрэг ажлуудыг хэлэлцэн уулзалт зохион байгууллаа



Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн удирдлага, төлөөлөгчид 2023 оны 10 сарын 30-наас 11 сарын 6-ны хооронд БНСУ-д ажлаад ирлээ

Тус ажлын хүрээнд БНСУ-ын Коже их сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа

Мөн Цахилгаанчин, Гагнуурчин мэргэжлээр хамтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр харилцан тохиролцлоо



"МЯНГАН ЦЭЦЭГСИЙН ЧУУЛГАН"

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн хамтран ажиллах ажлын хүрээнд зохион байгуулсан "Мянган цэцэгсийн чуулган"-ыг сургуулийн 320 охидын дунд зохион байгуулсан нь салбартаа анхдагч үйл ажиллагаа боллоо

Энэхүү үйл ажиллагааг ҮҮПК-ийн сургалтын албаны менежер Б.Мядагбадам нээж МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Ж.Нямаа Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн хөгжил хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн Б.Болор-Эрдэнэ, МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн Э.Бүжин нар "Нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Гэр бүл төлөвлөлт", "Өсвөр үе ба Ирээдүй", "Үе тэнгийнхний дээрэлхэлт" сэдвээр илтгэл тавьж оролцлоо. Мөн чуулганы хүрээнд ҮҮПК-ийн "Нарны охид" клуб албан ёсоор зохион байгуулагдаж нээлтээ хийлээ



☎ 976+11350209

📍 Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж

🌐 www.pas.mn

СУРАЛЦАГЧДЫГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА

“НУУЦЫГ ЭЗЭМШИГЧИД УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Улсын Драммын Эрдмийн Театраас “Нууцыг эзэмшигчид” уулзалтыг зохион байгууллаа. Театрын Үйлдвэр техникийн хэлтсийн ажил үйлсийг сурталчлах “Нууцыг эзэмшигчид уулзалтыг 2023.11.16 нд зохион байгуулж ҮУПК-ийн Сургалтын албаны менежер Б.Мядагбадам, МУУГЗ, УДЭТ-ийн найруулагч, УТХ-ийн дарга Ч.Түвшин, МУГЖ Ж.Оюундарь, Гэрлийн мастер МУСТАР.Мөнхцэцэг, Дууны найруулагч Т.Майдаржав, эрэгтэй хувцасны эрхлэгч МУСТА О.Гандөл, эмэгтэй хувцасны эрхлэгч МУСТА Н.Нямдарь, парик мастер МУСТА М.Энхтүвшин, нүүр будгийн мастер М.Сонинцэцэг ҮУПК-ийн 127 оюутан суралцагчид оролцлоо.



СУРГАЛТ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Хөөрхөн зүрх” ТББ-тай хамтран Гинжийг тасал хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 11 сарын 15, 11 сарын 16-ний өдрүүдэд нийт 189 суралцагчдын дунд зохион байгууллаа.



“ӨСВӨР ҮЕИЙНХЭН- БАЙГАЛЬ ОРЧИН БА ХУУЛЬ - II” ТӨСӨЛ

ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар Hanns Seidel Foundation Mongolia газраас ивээн тэтгэж, хамтран хэрэгжүүлж буй “Өсвөр үеийнхэн- Байгаль орчин ба хууль - II” төслийн хүрээнд Байгалийн Ухааны Тэнхимийн багш нарын санаачилгаар хамтран зохион байгуулсан МУИС-ийн Экологийн боловсролын төвийн танин мэдэхүйн өртөөчилсэн аялалд Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн төлөөлөгч болгон 200 сурагчид хамрагдаж нэгэн өдрийг үр бүтээлтэй өнгөрөөлөө.



SPELLING BEE ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

ҮУПК-ийн I курсийн суралцагчдын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг англи хэлний Spelling bee-I тэмцээн амжилттай болж өндөрлөлөө.



СУРАЛЦАГЧДЫГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА

"НАРНЫ ОХИД" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БОЛЛОО

Шинэ сарын эхний өдөр ХУТ-ийн "Би-гээс Бид" сарын аяны хүрээнд суралцагчдыг хөгжүүлэх чиглэлээр МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн Зөвлөлийн дарга Ж.Нямаатай уулзаж хамтарч ажиллах санал тавьж "Нарны охид" төслийг хэрэгжүүлэхээр боллоо.



НАНДИН ХАЙРЦАГ"

Өсвөрийн улаан загалмайн клубийн зүгээс "Нандин хайрцаг" буюу охидод сар болгон тулгардаг асуудлын үед зайлшгүй хэрэгтэй зүйлсийг хийж ариун цэврийн өрөөнд байршууллаа




МУ-ын мастер үсчин Н.Алтаншагайгийн нэрэмжит "Улсын аварга" шалгаруулах үсчин гоо засал, хумс урлалын II уралдаанд ҮҮПК-ийн үсчин мэргэжлийн багш, суралцагчид амжилттай оролцов




ЭЛЕКТРОН ТАМХИНААС ТАТГАЛЗЬЯ

"Утаат болон Электрон тамхинаас татгалзъя" аяны хүрээнд Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй" хамтран тамхинаас татгалзах цахим уриалгыг дэвшүүллээ.



CHALLENGE ЭХЛҮҮЛЛЭЭ.

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн оюутан, суралцагчид "Утаат болон электрон тамхинаас татгалзъя" аянд нэгдэж [#тамхинаастатгалзъя](#) challenge эхлүүлээ



976+11350209

Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж

www.pas.mn

СУРАЛЦАГЧДЫГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА

ТАМХИНААС ТАТГАЛЗЪЯ ӨДӨРЛӨГИЙГ" ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн сургуулийн эмч болон нийгмийн ажилтан багш нар хамтран "Утаат болон электрон тамхинаас татгалзъя" аяны хүрээнд суралцагчдад тамхины хор нөлөөг таниулах, суралцагчдыг хорт зуршлаас татгалзах тамхи татсанаар эрүүл мэндэд учруулах эрсдэлийг олон нийтэд таниулах зорилгоор Тамхинаас татгалзъя өдөрлөгийг зохион байгууллаа



СУРГАЛТ "ЗОХИОН БАЙГУУЛЛАА

МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Chungcheongnam мужийн Boryeong хотод байрлах Ажү автомашин инженерчлэлийн коллежийн удирдлагууд автомашин засварчин мэргэжлийн ангийн суралцагчидтай уулзалт зохион байгууллаа.



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь эерэг хандлага, эрүүл оюутан уриан дор явагдаж буй "ОЮУТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САРЫН АЯНЫ" хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран "Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнээс татгалзъя" сургалтыг оюутан, суралцагчдадаа зохион байгууллаа

Сургалтыг нээж Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл мэндийг дэмжих, мэдээллийн албаны дарга С.Гэрэлмаа оюутан суралцагчдадаа хандан үг хэлж, нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл мэндийг дэмжих, мэдээллийн албаны мэргэжилтэн Г.Бадамцэцэг Б.Наранжаргал нар сургалт явууллаа



МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Chungcheongnam мужийн Boryeong хотод байрлах Ажү автомашин инженерчлэлийн коллежийн удирдлагууд автомашин засварчин мэргэжлийн ангийн суралцагчидтай уулзалт зохион байгууллаа.



ЦАГИЙН МЕНЕЖМЕНТ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн Ёс зүйн сарын аяны хүрээнд Universal-Z номын клубын чиглүүлэгч багш Ч.Нямсүрэн болон клубын гишүүд хамтран "Би хариуцлагатай оюутан" уриалгыг дэвшүүлэн хичээлдээ хоцорсон суралцагчдын бүртгэлийн сарын туршид хийж тухайн суралцагчдад "Цагийн менежмент" гэсэн сэдвээр сургалтыг зохион байгууллаа. Мөн аяны хүрээнд суралцагчдын дүрэм журмыг QR хэлбэрээр суралцагчдад тарааж хэлэлцүүлэг өрнүүлэн ёс зүйтэй суралцагч байх уриалгыг дэвшүүллээ.



ОЛИМПИАД, УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Ерөнхий эрдмийн хичээлүүдээр мэргэжлийн боловсролын нэг болон хоёрдугаар ангийн суралцагчдын дунд олимпиад зохион байгууллаа.






$V = \frac{4}{3} \pi r^3$ МБС-ын I БОЛОН II АНГИЙН СУРАЛЦАГЧДЫН ДУНДАХ МАТЕМАТИКИЙН ОЛИМПИАДЫН ДҮН

МБС-ын 1-р ангийн дүн:

Тэргүүн байранд: ӨСО 1а М.Базаргүрэм
Дэд байранд: ӨСО 1а С.Оюундарь
Гутгаар байранд: ЗБЖБҮА 1а Б.Сувд-Эрдэнэ
Тусгай байранд: ӨСО 1а О.Билэгт
Тусгай байранд: ЗБЖБҮА 1а Б.Бямбадулам

МБС-ын 2-р ангийн дүн:

Тэргүүн байранд: ХГД 2а Б.Анужин
Дэд байранд: ОБО 2б О.Өнөрзаяа
Гутгаар байранд: ХГД 2а Э.Лхагвадорж
Тусгай байранд: НБДАХА 2а Н.Эрдэнэчимэг
Тусгай байранд: ГОО 2а С.Янжинлхам




$V = \frac{4}{3} \pi r^3$

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

2023-2024 оны хичээлийн жилийн "Шилдэг арга зүйч багш" шалгаруулах уралдаан амжилттай болж өндөрлөлөө.

Уралдаанд 7 тэнхимээс шалгарсан 7 багш арга зүйгээрээ уралдан ХУТ -ийн Түүх- нийгмийн багш Б.Урантогос 1-р байр, МТ-ийн тэнхимийн мэдээлийн технологийн багш Д. Отгондэмбэрэл 2-р байр, ТТТ-ийн авто засварын багш Д. Норовханд 3 -р байр эзэллээ.



НОМ УНШИХ УРИАЛГА ДЭВШҮҮЛЛЭЭ

Ч.Нямсүрэн багштай хэвлэлийн график дизайнч 1а ангийн хамт олон номын сангийн картаа 100 хувь нээлгэн суралцагч бүр ном уншиж хэлэлцүүлэг өрнүүллээ.



976+11350209

Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж

www.pas.mn

“АЖЛЫН БАЙРНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник коллежийн ХАБЭА-н ажилтан Б.Дамдинхорол “Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг” хэрхэн хийх талаар сургалтыг зохион байгууллаа



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Нягтлан бодох бүртгэл мэргэжлийн ангийн суралцагчдад ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ, БҮРТГЭЛ сэдвээр “Жи Эс Эккаунт ТМЗ” ХХК -ний Татварын мэргэшсэн нягтлан бодогч Б.Мөнхчимэгтэй хамтран сургалт уулзалтыг зохион байгууллаа



ШИЛДЭГ БҮТЭЭЛЭЭР ШАЛГАРЛАА

Design vitality-2023 наадмын гар урлалын төрөлд нийт 17 бүтээлээр мөн илтгэлийн төрөлд амжилттай оролцож Бэлэг дурсгалын зүйл урлаач мэргэжлийн “ЭПОКСИ ХҮҮХЭЛДЭЙ” гар урлалын төрөлд Шилдэг бүтээлээр шалгарлаа



”СОЁЛЫН ӨВ ДАРХЛАА БА ШИНЭЧЛЭЛ”

Барилга Технологийн Политехник коллеж байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан мэргэжил, зорилго, үйл ажиллагаа нэгтгэж хамт олныхоо хөгжлийг дэмжин хамтран ажиллах, харилцан туршлага солилцох, улмаар Монголчууд бидний бахархалт өв соёлын үнэт зүйлсийг мэргэжлийн боловсролын салбарын орчин үеийн хөгжилтэй хэрхэн уялдуулан Монгол брэнд болгох, үндэсний уламжлалт шинэчлэлийг шингэсэн ирээдүйтэй мэргэжилтэн бэлтгэх, бүтээлч багш, суралцагчдын хөгжлийг дэмжих тэдний хамтын бүтээлийг бий болгохсалбарынхаа оюуны чадамжийг нээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан “МОНГОЛЫН ӨВ СОЁЛ-МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛД” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд нийт 28 оролцогчдоос УУПК-ын сургалтын албаны менежер Б.Мядагбадам, багш Б.Анхбаяр, Н.Саруул нар нь “Соёлын өв дархлаа ба Шинэчлэл” сэдвээр амжилттай оролцож ДЭД БАЙР эзэллээ



СУРАЛЦАГЧИД НИЙТ 98 БҮТЭЭЛ ГАРГАЛАА



976+11350209

Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж

www.pas.mn